



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2018. 05. 23 № 25

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН САЙД  
Ц.ЦОГЗОЛМАА ТАНАА

Асуулга тавих тухай

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод дээд болон мэргэжлийн боловсролыг хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, ажлын байранд тавих шаардлагатай уялдуулан тасралтгүй хөгжүүлэх, чанарын баталгаажилт, магадлан итгэмжлэлийн тогтолцоог төгөлдөржүүлэх зорилт дэвшүүлсэн. Гэвч өнөөгийн нөхцөлд их дээд сургууль, коллежууд эрэлтээс давсан хэмжээгээр мэргэжилтэн бэлтгэж байгаагийн зэрэгцээ зарим төрийн бус өмчийн их, дээд сургууль сургалтын орчин, боловсон хүчний дутагдалтай, тэдгээрийг төгсөгчдийн онолын мэдлэг болон практик туршлага, ур чадвар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагыг хангаж чадахгүй байгаа нь ажилгүйдлийн түвшин нэмэгдэхэд хүргэж байна.

2017-2018 оны хичээлийн жилд улсын хэмжээнд нийт 155248 оюутан төрийн болон төрийн бус өмчийн 96 их, дээд сургууль, коллежид суралцаж байгаа бөгөөд 69 их, дээд сургууль, коллеж магадлан итгэмжлэгджээ. Жилд дунжаар 30-35 мянган залуус бакалаврын зэрэгтэй төгсөж байгаа ч тэдний 70-75 хувь нь ажилгүйчүүдийн эгнээнд шилжиж байна. Түүнчлэн бүртгэлтэй ажилгүй иргэдийн 31,7 хувийг дипломын болон бакалаврын дээд боловсролтой иргэд эзэлж байгаа бөгөөд залуус хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн тодорхой боловсрол, тусгай мэргэжил үл шаардагдах энгийн ажил эрхлэхээс аргагүйд хүрч байна.

Иймд сургалтын чанараас илүүтэй суралцагчдын тоо, ашгийн төлөө хэт анхаарал хандуулсан төрийн бус өмчийн их, дээд сургуулиудыг нэг мөр цэгцлэх, чанарын шаардлага хангаагүй сургуулиудын зэрэглэлийг бууруулах, боловсон хүчнийг хөдөлмөрийн зах зээл дээрх шингээлт бүхий салбаруудад түлхүү бэлтгэн нийлүүлэх чиглэлээр нэн яаралтай арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Улсын Их Хурлын гишүүн миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайд Ц.Цогзолмаа Танд дараахь асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын хүрээнд дээд боловсролын агуулга, стандарт, сургалтын чанарын үнэлгээг сайжруулж, чанарын баталгаажилт, магадлан итгэмжлэлийг олон улсын жишигт нийцүүлэн төгөлдөржүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ ба тодорхой үр дүнд хүрсэн эсэх тухай;

0000000042


2. Үндсэн багш, боловсон хүчний дутагдалтай, сургалтын болон оюутны дотуур байргүй, номын сан, биеийн тамирын танхим, практик дадлагын байр, мэргэжлийн лаборатори гэх зэрэг оюутныг хөгжүүлэх орчин бүрдүүлээгүй төрийн бус өмчийн их, дээд сургуулиудад яамны зүгээс тавьж буй шаардлага, бодлогын дэмжлэг туслалцаа болон тухайн сургуулиуд сургалтын бааз сууриа бэхжүүлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд хийгдсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тухай;
3. Чанарын шаардлага хангаагүй, магадлан итгэмжлэгдээгүй их, дээд сургуулиудыг коллеж, мэргэжлийн сургуулийн зэрэглэлтэй болгох чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай;
4. Элсэгчдэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцүүлэн мэргэжлээ зөв сонгох чиг баримжаа, ойлголт олгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ болон төгсөгчдийн ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшний талаарх судалгаа, статистик үзүүлэлтэд тулгуурлан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ажил олгогч, төрийн бус байгууллагуудтай хэрхэн уялдаа холбоотой хамтран ажиллаж байгаа тухай;

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасан хугацаанд бичгээр ирүүлж, улмаар Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанд сонгохыг Танаас хүсье.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт.

Хүндэтгэсэн:

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Х.БОЛОРЧУЛУУН